



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 11 нэрийн нийт 2,498,303.80 (хоёр сая дөрвөн зуун ерэн найман мянга гурван зуун гурван төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,249,151.90 (нэг сая хоёр зуун дөчин есөн мянга нэг зуун тавин нэгэн төгрөг ерэн мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005409
15-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ,
 ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэм жих нэгж	Ашиглалтад орсон огноо	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)		
							Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Цаашид ашиглах хугацаа
1	Принтер /HPM1102/	ш	2020.12.31	1	84,000.00	84,000.00	42,000.00	42,000.00	2
2	Гэрэл /хөлний хамт/	ш	2019.09.02	1	300,000.00	300,000.00	150,000.00	150,000.00	3
3	Утасны аппарат	ш	2019.12.30	1	125,000.00	125,000.00	62,500.00	62,500.00	2
4	Операторын чихэвч	ш	2019.12.30	1	120,000.00	120,000.00	60,000.00	60,000.00	2
5	Хөргөгч	ш	2017.12.31	1	500,000.00	500,000.00	250,000.00	250,000.00	3
6	Зөөврийн компьютер /dellii vostro 3500/	ш	2020.12.31	1	370,000.00	370,000.00	185,000.00	185,000.00	3
7	Утасны сүлжээний төхөөрөмж	ш	2020.12.31	1	22,000.00	22,000.00	11,000.00	11,000.00	2
8	Хаалт /12 EG/	ш	2011.10.19	1	130,246.90	130,246.90	65,123.45	65,123.45	3
9	Хаалт /16 EG/	ш	2011.10.19	1	158,176.90	158,176.90	79,088.45	79,088.45	3
10	Ус цэвэршүүлэгч /2015/	ш	2015.12.31	1	550,000.00	550,000.00	275,000.00	275,000.00	3
11	Хурлын сандал /ягаан дугуйтай/	ш	2005.01.01	1	138,880.00	138,880.00	69,440.00	69,440.00	3
	Дүн					2,498,303.80		1,249,151.90	